



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ – 2026 ОН

2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулсан тоо	Нээлттэй болгохоор хууль, журамд заасан мэдээллийг цахим системд байршуулсан байна.	2026.04.10-2026.12.01
2.	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудад сурталчилна.	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчилсан хэлбэр, тоо	Сурталчилгаа явуулсан байна.	2026.04.10-2026.12.01
3.	Салбарын хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус "түр орон гүйцэтгэгч" томилохыг зогсоох	Холбогдох хууль, журмын дагуу хийсэн томилгооны тоо	Холбогдох хууль, журмын дагуу томилгоо хийсэн байна.	2026.04.10-2026.12.01
4.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гарсаны дараа томилгоог баталгаажуулах	АТГ-ын хяналтад хамрагдсан томилгооны хувь	Тухай бүр АТГ-т ХАСУМ-ийг хянуулсан байна.	2026.04.10-2026.12.01

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
5.	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн болон хамаарал бүхий этгээдийн байгууллага руу өвчтөнийг чиглүүлэх үйл ажиллагаанд ёс зүйн хяналт тавих	Хяналт хийсэн тайлан	Хяналтаар гарсан зөрчлийг арилгасан байна.	2026.04.10-2026.12.01
6.	Ажилчдын шагнал, урамшууллыг бэлнээр эргүүлэн татах, зориулалтын бусаар (ойн баяр гэх мэт) зарцуулахыг таслан зогсоох, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах	Эрх бүхий байгууллагын дүгнэлтээр илэрсэн санхүүгийн зөрчлийн дүгнэлт	Зөрчлийг бүрэн арилгасан байна.	2026.04.10-2026.12.01
7.	Салбарын удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжилтнүүдэд Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Сургалтад хамрагдсан нийт ажилчдын эзлэх хувь - Зохион байгуулсан сургалтын тоо 	<ul style="list-style-type: none"> - ЭМЯ-ны харьяа байгууллагууд улиралд 1 сургалт зохион байгуулсан байх Ажилтнуудын оролцоо 90%-с дээш байх 	2026.04.10-2026.12.01
8.	Байгууллага бүр төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тендерийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг тухайд нь мэдээлэх	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний хувь	Үнэлгээний хувь 95%-с дээш байх	2026.04.10-2026.12.01
9.	Эрүүл мэндийн салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-с дээш байна.	2026.04.10-2026.12.01
10.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан зөрчлийг арилгах төлөвлөгөөг тухай бүр гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх	Ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн дагуу арилгасан зөрчлийн тоо	Зөвлөмжөөр өгсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх	2026.04.10-2026.12.01
11.	Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч төвтэй, хүндэтгэлтэй харилцаа, ёс зүйд суурилсан чанартай тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх хүрээнд “Хүндэтгэлтэй	<ul style="list-style-type: none"> - Улирал бүр аян зохион байгуулсан харьяа байгууллагын тоо - Ажилтнуудын оролцооны хувь 	<ul style="list-style-type: none"> - ЭМЯ-ны харьяа байгууллагууд улиралд 1 аян зохион байгуулсан байх 	2026.04.10-2026.12.01

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
	харилцаа – Чанартай тусламж” аян зохион байгуулах		- Ажилтнуудын оролцоо 90%-с дээш байх	
12.	Авлига, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах олон сувгийн (утас, цахим, саналын хайрцаг) тогтолцоог бүрдүүлж, мэдээлэгчийн нууцлалыг ханган, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Ажиллаж буй гомдол хүлээн авах сувгийн тоо (утас, цахим хайрцаг гэх мэт) - Ирсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хувь 	<ul style="list-style-type: none"> - Доод тал нь 2 төрлийн суваг тогтмол ажилладаг байх - Ирсэн гомдлын 90%-с дээш хувийг шийдвэрлэсэн байх 	2026.04.10-2026.12.01